



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/82/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим
хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Ж.Баяртуул

Утас: 70584207 Цахим хаяг: bayartuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	122
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	1213
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	144
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	155
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16





**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.13 № 55

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110519536



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сүмбэр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн хандиваар ирсэн хөрөнгийг баримтжуулах талаарх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 31-нээс 2020 оны 02 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 02/15 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.



Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хөдөлмөрийн зах зээлийн зохистой эрэлт, нийлүүлэлт, төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан, чадамжид суурилсан сургалтын цогц үйлчилгээг олон улсын стандартын түвшинд үзүүлэх үндэсний хэмжээний тэргүүлэх сургууль болох”-д оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймаг дахь Политехникийн коллеж нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acoulous” программ хангамж ашигладаг байна.

Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудлыг төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,107,448.3 мянган төгрөгөөс тооцон 42,148.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 52,099.1 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79,1301.2 мянган төгрөгөөр буюу 0.86 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материал данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	11,648.8	10,137.5	-1,511.2
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	1,202,008.2	1,030,956.7	-171,051.5
Үндсэн хөрөнгө	9,107,877.9	9,043,797.0	44,717.5
Элэгдлийн зардал	-2,616,247.9	-3,108,798.3	-492,550.4
Нийт хөрөнгө	7,705,286.9	7,084,891.2	-620,395.7
Өр төлбөр	5,163.1	5,931.2	768.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,478,921.7	4,478,921.7	-
Хуримтлагдсан үр дүн	-455,919.8	-1,077,083.6	-621,163.8
Өмнөх үеийн үр дүн	-455,919.9	-455,919.9	-
Тайлангийн үеийн үр дүн		-621,163.8	-621,163.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,677,122.0	3,677,122.0	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,705,286.9	7,084,891.2	-620,395.7

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь “Зүүн бүсийн арга зүйн төв” бүтэц зохион байгуулалтын хувьд тус байгууллагаас салснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант жилд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас үнэ төлбөргүй хөрөнгө шилжиж ирсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,084,891.2 мянган төгрөг болж -620,395.7 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгө шилжүүлсэн, элэгдлийн зардал өндөр дүнтэй байгаагаас шалтгаалсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн тайлант онд хадлангийн орлого 9'000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн нь бүрэн тасарсан байна.



Энэ нь тухайн байгууллага хадлан эрхлэх тусгай зөвшөөрөлгүй байхад туслах үйл ажиллагаанд орлогыг үндэслэлгүй төлөвлөсөнтэй холбоотой байна.

Хүснэгт 2: Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Туслах үйл ажиллагаа	9,000.0	0	-9,000.0	0
	Нийт дүн	9,000.0	0	-9,000.0	0

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,642,592.3 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд төлөвлөгдсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,221,249.8 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Тайлант жилд “GIZ” Германы олон улсын байгууллага, “Вагнер ази” ХХК, Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн гуравласан гэрээний дагуу 148.0 сая төгрөгийн нэмэлт төсвийг төвлөрүүлж, эксковаторын засварт зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 31 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 14 эрсдэл тодорхойлж нийт 18 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,498,738.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,778.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 227,730.8 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулж, 1,268,329.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 900.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

1. Тайлант хугацаанд хийсэн 64,701.1 мянган төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”*, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е



баримтыг хавсаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

2. Цалин болон НДШ-ийн зардлын нийт 1,194,628.4 мянган төгрөгийг ажил гүйлгээний утга болон гарсан цаг хугацааг үл хамааран нийлбэр дүнгээр нь журналд бүртгэсэн нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө” Төсвийн тухай хуулийн 26.1-т “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” 4. 3 дугаар хавсралтын “төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-тай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3. Тайлант жилд туслах үйл ажиллагаа болох хадлангаас 9,000.0 мянган төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсөн боловч төсвийн орлого тасарсан нь *Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “Төсвийн байгууллага дараах шаардлагыг хангасан тохиолдолд туслах үйл ажиллагаа явуулж, орлого олж болно”, 44.1.1-д “төсвийн ерөнхийлөн захирагч урьдчилан бичгээр зөвшөөрсөн байх”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

4. Тайлант жилд 646.3 мянган төгрөгийн шатахуун, 1,131.9 мянган төгрөгийн хүнсний материал нөөцөлсөн нь *Төсвийн тухай хуулийн 43.5 дахь “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Аудитаар илэрсэн 900.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймаг дахь Политехникийн газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.



Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон акт албан шаардлагын биелэлт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тээврийн хэрэгслийн ашиглалт

1.1. Илрүүлэлт: Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн захирал нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолд заасны дагуу албан тушаалын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад хамаарахгүй байхад 900.0 мянган төгрөгийн шатахууныг тодорхой ажлын гүйцэтгэлгүйгээр зарцуулсан байна.

1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.

1.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг мөрдөн ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1 213 657 000,02	1 041 094 258,87
33	АВЛАГА	11 648 760,79	10 137 549,00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00,00	961 549,00
335	Бусад авлага	11 648 760,79	9 176 000,00
3351	Байгууллагаас авах авлага	1 888 760,79	00,00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	9 760 000,00	9 176 000,00
35	БАРАА МАТЕРИАЛ	1 202 008 239,23	1 030 956 709,87
351	Түүхий эд материал	682 288 989,07	575 974 420,69
35110	Тусгай зориулалттай материал	682 288 989,07	575 972 420,69
35130	Эм боох материал	00,00	2 000,00
354	Хангамжийн материал	474 324 250,16	401 312 289,18
35410	Бичиг хэргийн материал	4 976 100,00	4 634 709,00
35420	Аж ахуйн материал	365 323 380,50	296 561 194,21
35430	Сэлбэг хэрэгсэл	242 875,30	00,00
35440	Түлш, шатах тослох материал	391 800,00	646 320,00
35450	Барилгын засварын материал	17 690 465,00	20 887 505,37
35460	Хүнсний материал	1 350 770,00	1 131 900,00
35470	Бусад хангамжийн материал	84 348 859,36	77 450 660,60
35600	Мал амьтад	45 395 000,00	53 670 000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6 491 629 899,67	6 043 796 988,32
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6 491 629 899,67	6 043 796 988,32
392	Биет хөрөнгө	4 774 855 008,59	4 327 022 097,24
39201	Барилга, байгууламж, орон сууц	4 469 453 532,00	4 469 453 532,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00,00	-322 783 089,48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	232 938 220,00	373 434 142,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-154 374 934,13	-168 903 555,63
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2 546 742 686,77	2 454 317 989,77
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2 365 170 021,42	-2 524 731 926,08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	98 999 424,57	94 909 869,57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-94 081 641,20	-89 758 404,71
39217	Ном	40 347 742,00	41 083 539,80
393	Биет бус хөрөнгө	1 716 774 891,08	1 716 774 891,08
39301	Програм хангамж	119 396 240,60	119 396 240,60
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2 621 349,52	-2 621 349,52
39303	Бусад биет бус хөрөнгө	1 600 000 000,00	1 600 000 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7 705 286 899,69	7 084 891 247,19
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5 163 132,00	5 931 230,00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5 163 132,00	5 931 230,00
413	Өглөг	5 163 132,00	5 931 230,00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	633 132,00	00,00
4136	Бусад өглөг	4 530 000,00	5 931 230,00
41361	Байгууллагад төлөх өглөг	00,00	111 230,00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	4 530 000,00	5 820 000,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7 700 123 767,69	7 078 960 017,19
51	Засгийн газрын хувь оролцоо	7 700 123 767,69	7 078 960 017,19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4 478 921 669,00	4 478 921 669,00
51101	Өмч: - төрийн	4 478 921 669,00	4 478 921 669,00
512	Хуримтлагдсан үр дүн	-455 919 845,52	-1 077 083 596,02
51210	Өмнөх үеийн үр дүн	291 702 109,35	-455 919 845,52
51220	Тайлант үеийн үр дүн	-747 621 954,87	-621 163 750,50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3 677 121 944,21	3 677 121 944,21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7 705 286 899,69	7 084 891 247,19



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1 667 344 589,29	2 062 460 535,64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	167 340 786,29	173 287 052,64
120	Нийтлэг татварын бус орлого	167 340 786,29	173 287 052,64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	167 340 786,29	173 287 052,64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62 203 800,00	66 885 590,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	570 000,00	00,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	104 566 986,29	106 401 462,64
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1 500 003 803,00	1 889 173 483,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1 366 457 800,00	1 642 592 300,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1 366 457 800,00	1 642 592 300,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	133 546 003,00	246 581 183,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт	133 546 003,00	246 581 183,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2 107 448 278,72	2 639 992 328,14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2 107 448 278,72	2 639 992 328,14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 946 475 902,92	2 505 374 110,14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	853 190 413,91	1 096 694 313,20
210101	Үндсэн цалин	841 923 413,91	1 075 634 753,20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00,00	404 440,00
210104	Урамшуулал	11 267 000,00	20 655 120,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98 359 369,00	126 676 887,79
210201	Тэтгэврийн даатгал	98 359 369,00	126 676 887,79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132 530 345,00	140 198 149,00
210301	Гэрэл, цахилгаан	27 601 393,00	38 062 943,00
210302	Түлш, халаалт	82 460 179,00	79 261 006,00
210303	Цэвэр, бохир ус	22 468 773,00	22 874 200,00
2104	Хангамж, бараа материалын зардал	13 359 730,00	15 757 191,00
210401	Бичиг хэрэг	1 478 950,00	3 245 537,00
210402	Тээвэр, шатахуун	4 729 650,00	5 474 916,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4 519 130,00	4 544 100,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2 632 000,00	1 787 988,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00,00	704 650,00
2105	Нормативт зардал	65 836 910,00	70 452 956,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	249 940,00	335 800,00
210502	Хоол, хүнс	64 084 000,00	62 799 016,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 502 970,00	7 318 140,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2 694 850,00	29 150 026,00
210604	Урсгал засвар	2 694 850,00	29 150 026,00
2107	Томилолт, зочны зардал	4 975 320,00	4 950 700,00
210702	Дотоод албан томилолт	4 975 320,00	4 950 700,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27 585 649,00	39 947 578,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23 920 200,00	36 400 858,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	830 000,00	1 194 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	1 000 000,00	1 200 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	982 098,00	622 720,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	853 351,00	530 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	747 943 316,01	981 546 309,15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14 933 534,00	61 663 897,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	238 514 889,25	307 470 639,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	494 494 892,76	612 411 773,15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	160 972 375,80	134 618 218,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	55 472 950,00	57 663 896,00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2 200 000,00	00,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13 472 600,00	00,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс	39 800 350,00	50 975 664,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00,00	6 688 232,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	105 499 425,80	76 954 322,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	105 499 425,80	76 954 322,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-440 103 689,43	-577 531 792,50
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00,00	43 631 958,00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00,00	43 631 958,00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00,00	-43 631 958,00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-440 103 689,43	-621 163 750,50



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1 560 826 505,50	1 953 643 535,00
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	57 543 800,00	68 759 590,00
120	Нийтлэг татварын бүс орлого	57 543 800,00	68 759 590,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	57 543 800,00	68 759 590,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	56 973 800,00	68 759 590,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	570 000,00	00,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1 503 282 705,50	1 884 883 945,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1 366 457 800,00	1 642 592 300,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1 366 457 800,00	1 642 592 300,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	136 824 905,50	242 291 645,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	136 824 905,50	242 291 645,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1 560 226 605,50	1 952 773 735,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 560 226 605,50	1 952 773 735,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 399 254 229,70	1 817 193 968,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	837 655 527,00	1 082 488 106,00
210101	Үндсэн цалин	639 345 461,00	745 451 066,00
210102	Нэмэгдэл	129 425 066,00	188 565 482,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57 618 000,00	57 618 000,00
210104	Урамшуулал	11 267 000,00	90 853 558,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98 093 500,00	127 268 111,00
210201	Тэтгэврийн даатгал	65 395 600,00	91 498 800,00
210202	Тэтгэмжийн даатгал	8 174 500,00	9 957 067,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6 539 600,00	7 024 444,00
210204	Ажилгүйдлийн даатгал	1 634 900,00	1 204 000,00
210205	Эрүүл мэндийн даатгал	16 348 900,00	17 583 800,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132 530 345,00	140 198 149,00
210301	Гэрэл, цахилгаан	27 601 393,00	38 062 943,00
210302	Түлш, халаалт	82 460 179,00	79 261 006,00
210303	Цэвэр, бохир ус	22 468 773,00	22 874 200,00
2104	Хангамж, бараа материалын зардал	16 597 704,00	16 608 146,00
210401	Бичиг хэрэг	2 945 200,00	3 033 599,00
210402	Тээвэр, шатахуун	4 204 500,00	4 207 500,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4 544 100,00	4 544 100,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2 632 000,00	2 640 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2 271 904,00	2 182 947,00
2105	Нормативт зардал	71 494 850,00	69 211 699,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	494 940,00	475 800,00
210502	Хоол, хүнс	65 247 424,00	62 799 016,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5 752 486,00	5 936 883,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8 006 900,00	24 906 828,00
210604	Урсгал засвар	8 006 900,00	24 906 828,00
2107	Томилолт, зочны зардал	4 969 000,00	5 041 400,00
210702	Дотоод албан томилолт	4 969 000,00	5 041 400,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32 915 449,00	40 976 957,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29 250 000,00	37 430 237,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	830 000,00	1 194 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	1 000 000,00	1 200 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	982 098,00	622 720,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	853 351,00	530 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	196 990 954,70	310 494 572,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26 848 255,00	178 209 517,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	170 142 699,70	132 285 055,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	160 972 375,80	135 579 767,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	55 472 950,00	57 663 896,00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2 200 000,00	00,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13 472 600,00	00,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	39 800 350,00	50 975 664,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00,00	6 688 232,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	105 499 425,80	77 915 871,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	105 499 425,80	77 915 871,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	599 900,00	869 800,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	599 900,00	869 800,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	599 900,00	869 800,00
2200	Дотоод эх үүсвэрээр	599 900,00	869 800,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	599 900,00	869 800,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-599 900,00	-869 800,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00,00	00,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх	2 416 048 306,00	1 982 138 361,40	291 702 109,35	00,00	4 689 888 776,75
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2 416 048 306,00	1 982 138 361,40	291 702 109,35	00,00	4 689 888 776,75
C07	Тайлант үеийн үр дүн	2 062 873 363,00	00,00	-440 103 689,43	00,00	1 622 769 673,57
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх	4 478 921 669,00	3 677 121 944,21	-455 919 845,52	00,00	7 700 123 767,69
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх	4 478 921 669,00	3 677 121 944,21	-455 919 845,52	00,00	7 700 123 767,69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4 478 921 669,00	3 677 121 944,21	-455 919 845,52	00,00	7 700 123 767,69
D08	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	-621 163 750,50	00,00	-621 163 750,50
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх	4 478 921 669,00	3 677 121 944,21	-1 077 083 596,02	00,00	7 078 960 017,19



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1 702 392 300,00	1 711 351 890,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 702 392 300,00	1 711 351 890,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 643 068 000,00	1 578 771 904,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1 076 456 100,00	1 070 019 898,00
210101	Үндсэн цалин	742 619 800,00	741 635 416,00
210102	Нэмэгдэл	194 017 300,00	188 565 482,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57 618 000,00	57 618 000,00
210104	Урамшуулал	82 201 000,00	82 201 000,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134 557 000,00	127 268 111,00
210201	Тэтгэврийн даатгал	95 311 208,00	91 498 800,00
210202	Тэтгэмжийн даатгал	10 091 775,00	9 957 067,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4 485 233,00	7 024 444,00
210204	Ажилгүйдлийн даатгал	2 242 617,00	1 204 000,00
210205	Эрүүл мэндийн даатгал	22 426 167,00	17 583 800,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160 778 700,00	140 198 149,00
210301	Гэрэл, цахилгаан	42 480 400,00	38 062 943,00
210302	Түлш, халаалт	92 574 900,00	79 261 006,00
210303	Цэвэр, бохир ус	25 723 400,00	22 874 200,00
210304	Байрны түрээс	00,00	00,00
2104	Хангамж, бараа материалын зардал	16 608 800,00	16 608 146,00
210401	Бичиг хэрэг	2 945 200,00	3 033 599,00
210402	Тээвэр, шатахуун	4 207 500,00	4 207 500,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4 544 100,00	4 544 100,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	2 640 000,00	2 640 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2 272 000,00	2 182 947,00
2105	Нормативт зардал	94 298 500,00	69 211 699,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	495 000,00	475 800,00
210502	Хоол, хүнс	87 863 500,00	62 799 016,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5 940 000,00	5 936 883,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24 906 900,00	24 906 828,00
210604	Урсгал засвар	24 906 900,00	24 906 828,00
2107	Томилолт, зочны зардал	5 049 000,00	5 041 400,00
210702	Дотоод албан томилолт	5 049 000,00	5 041 400,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	32 442 000,00	27 546 720,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	28 512 000,00	24 000 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 200 000,00	1 194 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	1 200 000,00	1 200 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1 000 000,00	622 720,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	530 000,00	530 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97971000,00	97970953,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	97 971 000,00	97 970 953,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59324300,00	55625664,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	59 324 300,00	55 625 664,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	54 674 300,00	50 975 664,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4 650 000,00	4 650 000,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1 702 392 300,00	1 711 351 890,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1 642 592 300,00	1 642 592 300,00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1 642 592 300,00	1 642 592 300,00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНАА	59 800 000,00	68 759 590,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50 800 000,00	68 759 590,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9 000 000,00	00,00